Хүүхдийн өвчнийг оношлох аргын түүх, онол, зарим практик хэрэглээг тодруулах судалгаа

Э.Анхмаа[1], П.Амартуяа[1], Н.Алтанзул[1], О.Шагдар[1], Г.Эрдэнэчимэг[2]

[1]Уламжлалт Эмчилгээний Тасаг, УХТЭ
[2]АШУҮИС
Цахим хаяг: loveanji325@gmail.com, Утас:99882035

Түлхүүр үг:

Хүүхдийн өвчнийг оношлох
Таван махбод
Чихний судас
Долоовор хурууны судас

Товч утга: Монголын уламжлалт анагаах ухааны хүүхдийн өвчнийг оношлох аргын түүх, онолын зарим асуудлыг тодруулан гаргаж улмаар цаашид дэлгэрүүлэн хөгжүүлэх үүднээс энэхүү асуудлыг сонголоо. Уламжлалт анагаах ухааны шүнгийн ном “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Судас барьж шинжлэх арга түүний эрт, эдүгээгийн тайлал тайлбар”, “Монгол эмнэлгийн дотор өвчний оношзүй” зохиолыг материал болгож ашиглав. Уламжлалт анагаах ухааны хүүхдийн өвчин судлалын салбарыг ч сэргээн хөгжүүлэх нь чухал байна.

Үндэслэл: Хүүхдийн бие махбод тасралтгүй өсөн бойжиж, хөгжидгөөрөө насанд хүрсэн хүний бие махбодоос олон талаараа өөр байдаг онцлогтой. Иймээс уламжлалт анагаах ухаанд хүүхдийн энэхүү онцлогт нь тохирсон асаргаа, сувилгаа, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ хийдэг. Ялангуяа хүүхдийн өвчин, түүнийг оношлох, эмчлэх асуудлыг бүхэлд нь хүүхдийн өвчин судлал хэмээн нэрлэж, уламжлалт анагаах ухааны бие даасан салбар гэж үздэг болохыг “Анагаах ухааны дөрвөн үндэс зохиолын “Увдисын үндэс”-ийн 71, 72, 73 дугаар бүлэгт тодорхой бичиж үлдээжээ[1]. Хүүхдийн бие махбод ба бие зүйн онцлог нь насанд хүрсэн хүнтэй адилгүй тул хурууны судал, чихний судал зэргийг үзэхээс гадна нүүр царайны өнгийг гол болгон нүд, шүд, хэл, толгойг үзэж шинжилнэ[2]. Уламжлалт анагаах ухааны салбар дотроос хүүхдийн өвчний оношзүй төдийлөн хөгжөөгүйн дээр уламжлалт анагаах ухааны эмч, сувилагч бэлтгэдэг их, дээд сургуульд энэ чиглэлийн хичээл бараг заагдахгүй байна. Иймээс бид Монголын уламжлалт анагаах ухааны хүүхдийн өвчнийг оношлох аргын түүх, онолын зарим асуудлыг тодруулан гаргаж улмаар цаашид дэлгэрүүлэн хөгжүүлэх үүднээс энэхүү асуудлыг сонгон авлаа.

Зорилго: Уламжлалт анагаах ухааны оношилгооны үндсэн хэсэг, онолын зарим асуудлыг тодруулан гаргаж хүүхдийн өвчний үед дэх оношилгооны аргыг тодруулах зорилго тавьж дараах зорилтыг дэвшүүлэн тавилаа.

Зорилт:

1. Хүүхдийн өвчнийг шинжлэх аргын түүхийн зарим асуудал, үүсэл гарлыг тодруулах
2. Асуух, үзэх, хүрэлцэх шинжилгээний аргуудыг ашиглан хүүхдийн эрүүл, өвчтэй, өвчтэй бол чухал болох шинж тэмдэг, өвчний хувирал, нас, орон, цаг агаар зэрэг бүх талаас нь задлан шинжилж, нэгтгэн дүгнэж оновчтой оношотгоох тухай онолыг судлах

Хэрэглэгдэхүүн ба арга аргачлал: Уламжлалт анагаах ухааны шүнгийн ном “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Судас барьж шинжлэх арга түүний эрт, эдүгээгийн тайлал тайлбар”, “Монгол эмнэлгийн дотор өвчний оношзүй” зохиолыг материал болгож ашиглав. Харьцуулалтын аргаар судалгааны нэг үр дүнг нөгөөтэй нь жишин үзэж төсөөтэй болон ялгаатай талыг тодруулан дүгнэлт өгөв.

Үр дүн:

1. Хүүхдийн өвчнийг шинжлэх аргын түүхийн зарим асуудал болон үүсэл гарлыг тодруулсан нь: XVI зууны сүүлчээс эхлэн уламжлалт анагаах ухаанд хүүхдийн өвчний оношзүй хөгжлийнхөө тодорхой түвшинд хүрч байсныг тодруулав. Монгол эмч маарамбууд хүүхдийн өвчнийг оношлох аргыг баяжуулан тун сонирхолтой байдлаар өөрсдийн бүтээлд тэмдэглэн үлдээжээ. Тухайлбал хүүхдийн чихний судас болон долоовор хурууны судсаар өвчнийг шинжиж мэддэг байжээ.

Гэвч харамсалтай нь оношилгооны энэхүү аргууд нь 1937 оноос 1990 он хүртэл бүр мөсөн мартагдсан хэмээн тэмдэглэжээ. 1990 оноос уламжлалт анагаах ухаан сэргээгдэн хөгжиж эхэлсэн ч зарим салбар түүний дотроос хүүхдийн өвчний оношзүй төдийлөн хөгжөөгүй байна.

2. Асуух, үзэх, хүрэлцэх шинжилгээний аргуудын онолын судалгаа:

Хүснэгт 1. Асууж шинжлэх

“Судас барьж шинжлэх арга түүний эрт, эдүгээгийн тайлал тайлбар” Ш. Болд 2018 он, “Анагаах ухааны дөрвөн үндэс” төвөд хэлнээс орчуулав
Хүүхдийн өвчний талаар өөрөөс нь асуухад хүндрэлтэй, мэдээлэл цуглуулах боломжгүй, ялангуяа үг хэлж чадахгүй буюу хэлсэн ч тодорхой, ойлгомжтой хариулт өгч чаддаггүй. Тиймээс эцэг эх, асран хамгаалагч нараас нь өвчний нөхцлийн талаар нарийн тодорхой асуух нь чухал.

Хүснэгт 2. Үзэж шинжлэх:

“Судас барьж шинжлэх арга түүний эрт, эдүгээгийн тайлал тайлбар” Ш. Болд	“Монгол эмнэлгийн дотор өвчний оношзүй” Д. Цэрэндагва, Б. Балдансамбуу
Хүүхдийг үзэж шинжлэхдээ цог жавхлан, өнгө зүс, ухаан мэдрэл, тамир тэнхээ, таван эрхтэнд гарах өөрчлөлт зэргийг онцлон үзнэ. **Түүнчлэн:** Хүүхдийн царайны байдлыг шинжлэхдээ цул, савын өвчний нүүр царайнд илрэх байдал, өнгөний илрэл, өнгө бүрийг таван махбодтой уялдуулан шинжилнэ. Жнь: Зүрхний өвчтэй бол магнайд, уушгины өвчтэй бол баруун хацарт, элэгний өвчтэй бол зүүн хацарт, дэлүүний өвчтэй бол хамрын хэсэгт, бөөрний өвчтэй бол эрүүнд тус тус шинж тэмдэг гарах бөгөөд илрэлийг өнгөөр ялган шинжилнэ.	Хүүхдийн нүүр царайны илрэл, толгой, хэл, нүд, хамар, уруул, чихний судлыг үзэж шинжлэн тухайн үеийн өвчнийх нь шинж чанар, хүнд хөнгөний байдал зэргийг жишиж мэдэх хэрэгтэй. **Учир нь:** Хүүхдийн нүүр царай арьс нь зөөлөн нимгэн, мах нь зөөлөн булбарай, хий цусны нэвтрэмжээр сайн учраас шинжлэхэд дөхөм бөгөөд хялбар. Жнь: Улайх нь уушги зүрхний хямарсан халуун, хөхрөх ба харлах нь тахал буюу өвчин хүндэрсэн, шарлах нь шар өвчин буюу элэг, цөсний гэм, цайвар болох нь бадган ба цусны тамир дорой.

Хүснэгт 3. Хүрэлцэж шинжлэх

“Судас барьж шинжлэх арга түүний эрт, эдүгээгийн тайлал тайлбар” Ш. Болд	“Монгол эмнэлгийн дотор өвчний оношзүй” Д. Цэрэндагва, Б. Балдансамбуу
Чихний судсыг үзэж өвнийг оношилох: Энэ аргаар 8 хүртэлх настай хүүхдийг шинжилнэ. Зарим тохиолдолд 15 нас хүртэлх хүүхдийг чихний дэлбэнгийн арын судсыг үзнэ. Хүүхдийн чихний хэлбэр, судасны байдал болон чихний халуун, хүйтнийг хүрэлцэж шинжлэх, судасны өнгийг шинжлэх аргыг гол болгосоор ирсэн. **Долоовор хурууны судсаар оношлох**: Хүүхдийн долоовор хурууны судсыг шинжлэхдээ эрхий долоовор хурууны салаанаас эрхий хуруу талд байгаа долоовор хурууны үзүүр тийш явсан судасны бүдүүн, нарийн болон өнгөний хувиралт, хурууны гурван үеийн аль хэсэгт судас гүрвийсэн буйг шинжилнэ. **Хүүхдийн бугуйн судсыг барих нь** Насанд хүрсэн хүнийхээс өөр байдгийг анхаарна. Барихдаа цон, ган, чагийн оронд үзэх шаардлаггүй. Эдгээр хэмжээг хүүхдийн шуунд онох боломжгүй байдаг тул хүүхдийн судсыг эмчийн долоовор эсвэл дунд хуруугаар үзнэ. Эрүүл хүүхдийн судасны лугшилт эмчийн нэг амьсгалд 6-7 лугшина.	**Чихний судсыг хүрэлцэх:** Хүүхдийн чихийг хүрэлцэж халуун, хүйтэн, чихний хэлбэр дүрс, өнгө, судсыг нарийвчлан үзэж, тухайн үеийн өвчний хувиралтын байдлыг шинжлэн танина. Хүүхдийн чихийг хөнгөн зөөлөвтөр барьж гэрлийн зүгт хандуулан шинжилнэ. **Үзэхдээ:** Чихийг дээд, дунд, доод гэж тэнцүү гурван хэсэгт хувааж, цул сав ба таван махбодтой уялдуулан шинжилнэ. **Эрүүл илрэл:** Чихэнд хүрэлцэхэд халуун, хүйтэн нь тэгш, судас нь ягаан өнгөтэй, нарийн бүдүүн нь тэгшхэн жигд илэрнэ. **Хүүхдийн долоовор хурууны судлыг шинжилж аливаа өвчнийг танин мэдэж болно.** Хүү бол зүүн гарын долоовор хуруу, охин бол баруун гарын долоовор хурууны судсыг шинжилнэ. Үзэхдээ анхдугаар үе хийн, дунд үе тамирын, эцсийн үе амь орон болно хэмээжээ. Эрүүл бол судал нь тодорхой, шулуун олонхдоо анхны байдлаа давтахгүй өнгө нь улаавтар, илэхэд судал нь илэрч, зогсвол үл мэдэгдэнэ.

Дүгнэлт:

1. Орчин цагийн анагаах ухаан дахь хүүхдийн анагаахын чиглэлээр хүүхдийн эрүүл мэндийн олон талт тулгамдсан асуудлыг зохих түвшинд шийдвэрлэж, салбар бүрт мэргэшсэн эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн байдаг. Үүнтэй адил уламжлалт анагаах ухааны хүүхдийн өвчин судлалын салбарыг ч сэргээн хөгжүүлэх нь чухал байна.
2. Хүүхдийн өвчний оношилгооны үед чихний арын судас, долоовор хурууны судлыг онцгойлон шинжилж үзнэ. Хүүхдийн нүүр царайны байдлыг шинжлэхдээ таван цэцэг болон цул, сав эрхтэнтэй уялдуулан шинжлэх нь оношилгооны чухал ач холбогдолтой байна. Шаардлагатай тохиолдолд хүүхдийн бугуйн судсыг барих нь насанд хүрсэн хүнийхээс өөр байдгийг анхаарах нь зүйтэй юм.

Ном зүй:

1. *"Судас барьж шинжлэх арга түүний эрт, эдүгээгийн тайлал тайлбар" Ш. Болд 2018 он*
2. *"Монгол эмнэлгийн дотор өвчний оношзүй" Д. Цэрэндагва, Б. Балдансамбуу 2003 он*
3. *"Онош зүй" Г. Одонцэцэг, Д. Нацагдорж 2010 он*
4. *"Монголын уламжлалт анагаах ухаан" Ч. Баавгай, Б. Болдсайхан 1990 он*
5. *"Хүүхдийн өвний онош зүй" Д. Малчинхүү 2016 он*
6. *"Анагаах ухааны дөрвөн үндэс" төвөд хэлнээс орчуулав.*
7. *"Монголын Уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увидас" Р.Сээсрэгдорж, Ч.Чимэдрагчаа, С.Хишигжаргал, Д.Цэрэндагва, Д.Чулуунчимэг, П.Молорэрдэнэ 2012 он*
8. *"Монголчуудын эрүүл амьдрах үндэс" Ш.Болд 2008 он 186-188 хуудас*
9. *Оточ Манрамба дээд сургуулийн 20 жилийн ойд зориулсан "Уламжлалт анагаах ухаан" эрдмийн чуулган \илтгэлийн хураангуй\ 2011 он*

A study to clarify the history, theory and some practical applications of pediatric diagnostic methods

E.Ankhmaa[1], P.Amartuya[1], N.Altanzul[1], O.Shagdar[1], G.Erdenechimeg[2]

[1]Traditional Medicine Department, UHTE
[2]MNUMS
E-mail: loveanji325@gmail.com ,Tel: 99882035

Abstract: This issue was chosen to clarify some of the historical and theoretical issues of Mongolian traditional medicine's method of diagnosing pediatric diseases and to further develop it. The book "Four Basics of Traditional Medicine", "Vascular Palpation Examination Method, its Past and Present Interpretations", and "Diagnostics of Internal Diseases in Mongolian Traditional Medicine" were used as material. It is important to revive the field of pediatrics in traditional medicine.

Keywords: Diagnosis of pediatric diseases, five elements, coronary artery, forefinger